



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/219

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор төрийн үйлчилгээний чирэгдлийг багасгах, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүн амын төвлөрөл ихтэй Бор-Өндөр суманд эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэх, сүлжээнд холбоход шаардагдах зардалд 4566000 /дөрвөн сая таван зуун жаран зургаан мянга/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

011038

Аймгийн Засаг даргын 2017 оны
06 дугаар сарын 08 өдрийн 112/19
дугаар захирамжийн хавсралт

Бор -Өндөр суманд тавигдах сүлжээний шаардагдах материалын төсөв

№	Материалын нэр	хэмжээ	Тоо	нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	internet modem	ш	2	400000	800000
2	media convertor		2	160000	320000
3	жампар кабель	куб.м	8	7500	60000
4	pern кабель	ш	30	1200	36000
5	холболтын хураамж	ш	1	350000	350000
Нийт дүн					1566000

Бор-Өндөр суманд тавигдсан холбооны суваг ашигласны төлбөр

Сар	суваг ашигласны төлбөр	Талбайн хэмжээ	Сарын төлбөр	Нийт дүн
1	1 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
2	2 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
3	3 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
4	4 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
5	5 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
6	6 сарын суваг ашигласны төлбөр	1	500000	500,000.00
Нийт дүн				3,000,000.00